

**НИЙСЛЭЛ ХОТЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ
ХУУЛИЙН ТӨСЛИЙГ АНХНЫ ХЭЛЭЛЦҮҮЛЭГТ БЭЛТГЭСЭН ТАЛААР
ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНООС ГАРГАСАН САНАЛ, ДҮГНЭЛТ**

2015 оны 05 дугаар
сарын 06-ны өдөр

Улаанбаатар
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын
гишүүн Д.Ганхуяг**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2014 оны 12 дугаар сарын 30-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Нийслэл хотын албан татварын тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын чуулганы 2015 оны 01 дүгээр сарын 09, 10-ны өдрүүдийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцээд, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Тус Байнгын хороо дээрх хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг 2015 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцээд дараах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанд оруулж танилцуулахаар шийдвэрлэлээ.

Төслийг Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ч.Хүрэлбаатар эдийн засгийн хүндрэлтэй, хямралд ороод байгаа энэ үед ард иргэдээс татвар нэмж авах нь буруу, энэ татвар нь төсөвт төвлөрөхгүй хүндрэл үүсэх тул хэлэлцүүлгийг хойшлуулъя гэсэн санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй бөгөөд энэ асуудлаар Улсын Их Хурлын гишүүн Ч.Хүрэлбаатар цөөнх боллоо.


Хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж, та бүхэнд тараасан болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Нийслэл хотын албан татварын тухай хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай асуудлаар Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллуудыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА**



Б.БОЛОР